

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Тендер шалгаруулалтын нэр: **“Эрчим хүчний хэрэглээний аудит”**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202312125**

1. **“Монголросцветмет” ТӨҮГ** нь **“Эрчим хүчний хэрэглээний аудит” гүйцэтгүүлэх** зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **“Монголросцветмет” ТӨҮГ-ын Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжуудын эрчим хүчний хэрэглээнд судалгаа шинжилгээ хийж, эрчим хүчний хэрэглээ, хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг боловсруулан аудитын тайлан гаргаж, холбогдох байгууллагад зөвшилцөн батлуулах зорилготой** болно.

3. Тендер нь дараах багцуудаас бүрдэнэ. Үүнд: - **Багцгүй**

4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Үүнээс гадна дараах мэдээллүүдийг нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:

- *Байгууллагын ерөнхий танилцуулга*
- *Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.*
- *Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай бөгөөд цахим системээр ирүүлсэн лавлагаагаар үнэлнэ.*
- *2021,2022,2023 оны санхүүгийн тайланг ирүүлэх /Сангийн сайдын 2019.12.09-ний өдрийн 255 тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.7 заалтыг баримтална./*
- *Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын орлого: Батлагдсан төсөвт өртгийн 30%-иас багагүй байна.*
- *Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ.: Батлагдсан төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх.*
- *Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.*
- *Эрчим хүчний аудит хийх магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээ.*

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2023 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 17.00** цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ **2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 9.00** цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ